



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 28 өдөр

Дугаар А/759

Булган сум

Газар эзэмших эрхийг хүчингүй болгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.1 дэх заалт, Монгол Улсын Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 08 дугаар сарын 6-ны өдрийн 221/МА2024/526 тоот магадлал, Монгол Улсын Дээд шүүхийн захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн хуралдааны 001/ШХТ2024/0402 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Монгол даатгал" ХК (РД:2032317) нь гадаадын иргэний 99.79 хувийн хөрөнгө оруулалттай нь тогтоогдсон тул тус компанийн эзэмшиж байсан Булган сум 5 дугаар баг Анхдагчдын өргөн чөлөө 1 дүгээр гудамж 1266 тоотод байршилтай 6308007256 нэгж талбар албан конторын зориулалттай "Монгол даатгал" ХК-ийн газар эзэмших эрхийг хүчингүй болгосугай.

2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан газрын улсын бүртгэлд өөрчлөлт оруулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Д.ПҮРЭВ-ОЧИР

